



Орхон аймгийн ЗДТГазар

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНИЙ ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

2015 оны 04-р сарын 06-ны өдөр

**1. Орон сууцны байрны
цахилгаан, дулааны үнэ
нэмэгдсэн асуудлаар
олон нийтэд мэдээлэл
өгөх:**

- **Биелэлт:** Орон нутгийн “Номин” телевизээр “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ний ерөнхий инженер, эдийн засагч, борлуулалтын албаны дарга, инженер нар айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын цахилгаан, дулаан, усны үнийн нэмэгдэлийн тухай, оршин суугчдын халаалтын хөлс тооцох талбайг нэмэгдүүлсэн ЭХЗХ-ны 2014-оны 192,196,189-р тогтоолууд болон Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2014-оны 71-р тогтоолуудын тухай болон бусад олон асуудлаар шууд ярилцлагад оролцож иргэдээс ирсэн асуулт, санал хүсэлтэнд хариулт өгсөн. Мөн “Шинэ мэдээ” сонины 2014-оны 3-р сарын 29-ны өдрийн дугаарт нийтэлж иргэдэд мэдээлэл өгсөн.

**2. Орхон аймгийн хэмжээнд
2015 оныг “Үйлдвэрлэл,
бизнесийг дэмжих жил”
болгох чиглэлээр санал
боловсруулж танилцуулах
/төлөвлөгөөний төсөл/:**




- **Биелэлт**

Төлөвлөгөөний төслийг
бэлэн болгож

удирдлагуудад
танилцуулж байна.

**3. Аймгийн хэмжээнд авто зам,
нийтийн тээврийн бодлогыг
шинэчлэн боловсруулах,
нийтийн тээврийн үйлчилгээг
сайжруулах талаар дорвитой
ажил зохион байгуулах: :**

- **Биелэлт** : Аймгийн Засаг даргын 2015 оны А/110 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд нийтийн тээврийн бодлого боловсруулах ажлын хэсэг байгуулагдан судалгаа хийж байна.



**4. БОЭТ-ийн үйл
ажиллагаанд тулгамдаж
буй зарим асуудлуудыг
шийдвэрлүүлэх талаар
санал танилцуулах:**

- **Биелэлт:** Зөөврийн болон суурин ЭХО-ийн 2 аппарат эвдэрсэнээс хүлээгдэл үүссэн. Үүнийг худалдан авах засуулах талаар Аймгийн ИТХ болон Төрийн сангийн хэлтэст саналаа хүргүүлсэн байна. Эмийн тасалдал тендер зарлагдсан боловч ханган нийлүүлэлт жигдрэхгүй байна. Эмийн төсвийг 365,0 сая төгрөгөөр танасан нь эм эмнэлэгийн хэрэгслэлийн нийлүүлэлтэнд хүндрэл учирч байна. Эм эмнэлэгийн хэрэгслэлийн хангалт нэн хэрэгцээт оношлогооны болон эмчилгээний тоног төхөөрөөмжийн талаар Эрүүл мэнд, Спортын яам болон орон нутагт саналыг хүргүүлээд байна.
- Лавлагаа цаг товлолт дээр интернэтийн хурдаас хамааран 7-10 хоногийн дараалал үүссэнийг “Актив холболт” ХХК хурдыг 2 дахин нэмэгдүүлэн 4 МВ болгож хүлээгдэлийг арилгасан.
- Дотор болон мэдрэлийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн хүлээгдэлийг Дэнж багт баригдсан 40 ортой эмнэлэгийг нээн ажиллуулсанаар хүлээгдэлийг 60,0 %-иар бууруулсан байна. Цаашид хэвийн үйл ажиллагааг хангахын тулд шаардлагатай төсөв мөнгө болон тохижилт үйлчилгээний ажлуудыг хийхээр Орон нутаг болон Эрүүл мэнд спортын яаманд хүсэлт тавьсан болно.

**5. Ой хээрийн түймрээс
урьдчилан сэргийлэх ажлыг
эртнээс төлөвлөн зохион
байгуулах, хотын доторх болон
ойр орчмын ногоон
байгууламжийг гал түймрээс
хамгаалах талаар анхаарч
ажиллах**

- **Биелэлт :** Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 2015 оны тодотгол хийж байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн нэгж байгууллагуудад ой, хээрийн түймрийн дайчилгаагаар ажиллах хүн хүч техник хэрэгслийн судалгааг авч ажиллаа.
- Онцгой байдлын газар, Байгаль орчны газар хамтран аймгийн хэмжээнд 2015 онд “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх” ажлын төлөвлөгөөг гарган аймгийн Засаг даргад танилцуулан холбогдох шийдвэр гаргуулахаар бэлтгэл ажил хангагдаж байна.
- Аймгийн төвийн эргэн тойрны ногоон бүсэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ногоон бүсийн эргүүл шалгалтыг 8 чиглэлд давхардсан тоогоор 85 алба хаагч хамрагдаж 8 зөрчил дутагдалыг газар дээр нь арилган ажилласан байна. Мөн Баянцагаан, Цагаанчулуут багийн иргэдэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөрлөг зохион байгуулж 235 иргэн хамрагдсан байна.
- Ард иргэдэд цаг үеийн холбогдолтой шуурхай мэдээ, мэдээлэл, Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хуурайшилтын үед иргэн хүн юу анхаарах зэрэг сэдвүүдээр өдөр бүр орон нутгийн хэвлэл мэдээллийн 5 телевиз, 4 “FM” богино долгионы радиогоор өдөр бүр 2 цагийн дамтамжтайгаар ард иргэдэд ухуулга сурталчилгааг явуулсан.

**6. 2015 оны 3-р сарын 28-29-
ний өдрийг аймгийн
хэмжээнд бүх нийтийн
цэвэрлэгээний өдөр болгож,
хог хаягдлыг цэвэрлэх,
тээвэрлэх ажлыг зохион
байгуулах**

- **Биелэлт** : Баян-Өндөр сумын Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 24-ны өдөр Нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулах тухай 96 дугаар захирамж гарч 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдөр нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулсан байна. Тус арга хэмжээний хүрээнд 21 багийн 471 аж ахуй нэгж байгууллага, 4217 иргэн оролцож 58300 м² талбайн 432 м³ хог хаягдлыг цэвэрлэж хогийн төвлөрсөн цэгт ачуулсан байна.



Анхаарал тавьсанд баярлалаа



2015 ОНЫ 04 САРЫН 06